

Барилгын хөгжлийн төвийн захирлын туша
Дугаар.
Хавсралт


Барилгын хөгжлийн төв
Барилга, байгууламжийн зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

Барилга, байгууламжийн зураг төслийн бүрдэл хэсгийн нэр **/Барилгын төсөв:/**

Увс аймаг тэс сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгын нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих төслийн ажлын зураг

2023 оны 10 сарын 29 өд

Д/д	Утга	Тайлбар
1	Барилга байгууламжийн нэр	Увс аймаг тэс сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгын нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих төслийн ажлын зураг
2	Барилга байгууламжийн байршил, хүчин чадал	Увс аймаг, Тэс сум, 0-р баг
3	Зураг төслийн байгууллага	"ДНТ" ХХК
4	Зургийн шифр	
5	Хуудасны тоо	
6. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоос/		
1	6.12.1. архитектур төлөвлөлтийн болон зургийн даалгавар, загвар зураг, эх загвар зураг/эскиз/, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүдийг тодорхойлсон, техникийн нөхцөлтэй эсэх;	
2	6.12.2. холбогдох мэргэжлийн байгууллагаар энэ дүрмийн 5.2-т заасны дагуу хянуулж, дүгнэлт гаргуулж баталгаажуулсан эсэх;	
3	6.12.3. барилга байгууламжийн архитектур төлөвлөлт, барилга бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь норм, нормативын баримт бичиг, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцлийн дагуу боловсруулсан эсэх;	

Д/д	Утга	Тайлбар
4	6.12.4. хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангуулсан эсэх;	
5	6.12.5. барилгын ажлын талбай, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагыг тусгасан эсэх;	
6	6.12.6. инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаарх дүгнэлттэй эсэх;	
7	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангуулсан эсэх;	
8	6.12.8. эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;	
9	6.12.9. зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх.	
<p>Дүгнэлт бичсэн Эксперт № 9-1</p> <p>Ү.Банди /  /</p> <p>2023 оны 10 сарын 29 өдөр</p>		

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН НЭР

*Увс аймаг тэс сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгын нүхэн жорлонг ариун
цэврийн байгууламжаар солих төслийн ажлын зураг*

2023 оны 10 сарын 29 өдө



Д/ д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Биелэлт
1	<p><u>А.ЕРӨНХИЙ ХЭСЭГ</u></p> <p>1.Хянуулахаар ирсэн төсвийн дүн</p> <p>ХҮБ 107 280 119₮</p> <p>ТУБ 130 418 814 ₮</p> <p>Цэц 49 447 650₮</p> <p>ДБ 80- 57 296 139₮</p> <p>ДБ-100- 58 834 292₮</p> <p>3-р байр 53 606 913₮</p> <p>320 үүхэд сургууль 53 971 926₮</p> <p>2. Төсвийн суурь, норм, үнэлгээ, төсөв зохиох дүрэм, холбогдох эрх зүйн актыг мөрдсөн эсэх</p> <p>Мөрдсөн.</p> <p>3. Зургаас түүвэрлэсэн ажлын объём материалын нэр төрөл, тоо хэмжээний үнэн зөв эсэх</p> <p>Зургийн компани, төсөвчин тоо хэмжээний үнэн зөвийг хариуцна.</p> <p>4. БХБСайдын 2016 оны12.26-ний өдрийн 203-р тушаалаар баталсан нэгж хүчин чадлын жишиг үнэлгээтэй харьцуулсан тооцоо хийсэн эсэх</p> <p>НХЧ-ын жишиг үнэлгээтэй харьцуулсан тооцоо хийгээгүй.</p> <p>5. Материалын тооцоог ажлын технологи, үе шатны ажлын төрөл тус бүрд зааглан тооцсон эсэх</p> <p>Зааглаж тооцсон.</p> <p>6. Материалын хэмжих нэгжийн харгалзах тоон утгын илэрхийллийг хянасан.</p> <p>Төсөвт тэмдэглэсэн хуудас бүрд нэг бүрчлэн үзэж зас.</p>	<p>НХЧ-ын жишиг үнэлгээтэй харьцуулсан тооцоо хийж, төсөвт тэмдэглэсэн хуудас бүр дээрхийн дагуу засав.</p>

Д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Биелэлт
2	<p><u>Б.САНАЛ, АЛДАА, ЗӨРЧЛИЙН ХЭСЭГ</u></p> <p>7. Төсвийн нүүр хуудас, тайлбарыг батлагдсан загвараар хийх. Нэг хүчин чадлын жишиг үнэлгээтэй харьцуулдаг өртгийн задаргааны тооцоог БХТөвөөс мөрдүүлж буй хүснэгтийн дагуу хийх. Цаашид экспертэд төсөв хийсэн эзэн нь тодорхой бус, хагас дутуу төсвийн тооцоо ирүүлэхгүй байх. Хатуу анхааруулъя.</p>	хүснэгтийг хийж гүйцэтгэсэн
3	<p>8. Зураг төслийн нэр " Нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих" гэж ядруухан агуулгадаа тохирохгүй нэршлийг өөрчлөх. Нүхэн жорлонгий нь аваад ариун цэврийн байгууламж оронд нь өгч солих агуулга байх юм. Ариун цэврийн байгууламж шинээр /хийх/ барих гэвэл нүхэн жорлонгийн..... сургуульд ариун цэврийн байгууламж шинээр барих гэх. агуулга л баймаар.</p>	
4	<p>9. Төсвийн, зургийг хийж буя компани, төсөвчих өөртөө зориулж хийдэггүй, бусдад зориулж хийдэг. Бусад нь түүнийг хэрэглэж, ажил, үйлдвэрлэл, явуулж барилга барьдаг тул бүх юм тодорхой байх ёстой. Иймд төсөв тус бүрийн гарчиг, нэрийг бүрэн бүтнээр бич. " 50 хүүхдийн /хар үзүүр баг/" гэхээр хэн ойлгох юм? Албан ажил, албан нэр хаяг, гарчигаар байдаг.</p>	Эксперттэйгээ ярилцаж ойлгомжтой байдлаар бичин засварласан.
5	<p>10. Нэг сумын 7 байршилд хийх энэ ажлын төсвийг тус бүрд нь хийсэн дүнгүүдээр төсөвт өртгийн нэгдсэн товчоонд төсөв дээр тэмдэглэсэн загварын дагуу хийх. Төсөв зохиох дүрэмд ийм шаардлага байгаа.Төсөв зохиох дүрмээ уншаарай.</p>	нэгтгэн хийв.
6	<p>11. Төсвийн тайлбар үгүй болохоор материалын үнийг ямар үндэслэлээр хаанаас авсан нь тодорхойгүй байна. Материалын үнийг 2023 оны Барилгын мэдээлэл сэтгүүлийн 2-р сарын дугаарт БХТөвөөс нийтлүүлсэн жагсаалтаас авч тусгах.</p>	Материалуудын үнийг засаж товч тайлбараа нэмж хавсаргав.

Д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Биелэлт
7	12. Хөнгөн цагаан булан, бариул, хаалт, чиг өөрчлөгч, холбох хэрэгслүүд, отвод, ламп, розетка, унтраалга, хавчаар, өвдгөвч, бугуйвч, бортого гэх мэт олон материалын тоон утгыг хянаж, хэмжих нэгжийн агуулгад тохируулж зас. Засахдаа хуудас нэг бүрээр үзэж тэмдэглэсэнтэй танилц.	хийж гүйцэтгэсэн.
8	13. Ажлын тоо хэмжээ, материалын хэрэгцээ зэргийг ажлын зураг, тооцоотойгоо нягталж шалгаж үз.	нягталж шалган засах зүйлсээ заслаа.
9	14. 60 х60-ын хэмжээтэй гипсэн хавтан дүүжин таазыг ширхэгээр үнэлэхгүй, тэгэж зарж ч худалддаггүй. Захын булан төмөр, зам Т төмрийн хамт м2-аар бодож үнэл. Танай тооцоонд 1ш-15500₮ нь зам ба булан төмрийн хамт 1м2-ын үнэ байна. Үүнийг судалж нягталж зас.	хийж гүйцэтгэсэн.
10	15. Заслалын ажилд 1ш-1050 ₮-ийн хөнгөн цагаан булан төмрийг ямар зориулалттай, юунд хэрэглэнэ гэж тооцсоноо мэдэж байна уу? Ямар, огтлолтой, хэдэн м урттайг 1ш гэж үнэлсэнээ тайлбарла.	буруу материал тооцсон байна. Засаж янзлав.
11	16. Цонхны тавцангийн үнэ ширхэгээр юм бол ямар өргөнтэй, ямар урттай, ямар материалын үнэ вэ? Үнэ? Хөдөөний ийм нөхцөл дэх барилгад заавал чулуу байх албагүй, хуванцар, чанартай, зориулалтын олон янзын өргөнтэй, өргөнөөсөө хамаарч 1м-ийн үнэ өөр тавцангуудаар хийх нь зүйтэй. Тодорхой болго.	БА - ийн зураг дээр чулуун тавцангаар тусгаж өгсөн байсан. Мөн хэмжээг нь тодорхой болгож тусгав.

Д/ д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Биелэлт
12	<p>17. Цемент 135,0-145,0 мянган₮-ийн үнэтэй хаана байна? Зах зээл, үнээ судал. Зас. 245,0 мянга гээд янз бүрээр байна. Шахмал хавтан гэж юуг хэлээд байна? Үртсэн шахмал, зоргодсон шахмал, шохой /гипсэн/-н шахмал, цаасан /метапон/ шахмал гээд олон янз байдаг. Эдгээрээс нэг нь ч м2-60000₮ хаана ч байхгүй.</p> <p>1,22 x 2,44-ын хэмжээтэй 1ш- үртэс /ДСП/-н хавтангийн 1ш-ийн үнэ байна. /1ш-2,98м2/</p>	уг илэрсэн алдаа зөрчлөө хянаж засварлав.
13	<p>18. Шалны банз м3-308000₮ үнэ судал. Заавал м3-ээр үнэлэх шаардлагагүй. Ажлын тооцоонд чинь банзан шалны ажил байхгүй байна. Хаана орох вэ? Нөхөөс бол м2-аар үнэл. Ажилд тусгах ёстой.</p>	засвар хийсэн.
14	<p>19. Сэнс, яндан өрөм, тохируулах хаалт, дулаалгын материал, тусгаарлах таглаа гэх мэт ш, м-ээр үнэлсэн бүх материалуудын марк, диаметр бусад хэмжээсүүд, зориулалт нэр зэргийг тодорхой болгох. Юун ч мэдэгдэхгүй байна. Яндан өрөм гэдэг чинь бага хэрэгсэлд орно.Зас.</p>	зассан.
15	<p>20. Тоосго, үртэс, түлээ, арчих материал, модон тоосго, модон таг, бетон зуурмаг гэх мэтийг УБ хотоос зөөх хэрэг үү? Увсад бохирын худгийн цагираг бетонууд, улны болон таг, ялуу зэрэг жижиг бетон ба төмөр бетон эдлэл үйлдвэрлэдэг байх. УБ-аас биш гэхэд тэндээс авахаар тооцох. Бүх материалыг УБ-аас зөөнө гэж байхгүйээ. Ер нь цөөн тооны бага хэмжээтэй жижиг хэрэглээний энэ барилгын бүх материалыг УБ-аас зөөх шаардлага байгаа юмуу? Увсаас хангахаар боломж бий эсэх талаар захиалагчтай зөвлөлдөж ярилц.</p>	Яг тодорхой ажиллаж байгаа бетон ба төмөр бетон эдлэлийн үйлдвэрүүд байгаа эсэх нь мэдэгдэхгүй байна. Хайж үзээд холбоо барихаар ажиллахаа больсон, ашиглалтанд байхгүй байна зэрэг хариу ирээд байгаа учир мэдэгдэхгүй байна. Гэхдээ таны хэлсэнчлэн ойртуулж багцаалдан 40км ээс тээвэрлэхээр тооцов.

Д/ д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Биелэлт
16	21. Нэг төрлийн нэг маркын, ижил төрлийн материалуудын үнийг янз бүрээр тусгаж тооцоонд авах шаардлагагүй. Нэг ижил үнээр тооцох зарчим баримтал. Эрэг шураг гэхэд л кг-1400₮,650₮,5200₮ 1300₮ 10200₮ гэх мэтээр дураараа үнэ тавьсан байна.	хянаж засварлалаа.
17	22. Давхар цонхны эвлүүлэг гэж цонхоо хэлсэн байх 1м2-50000₮, хүүхдийн суултуур, угаагуур, хөтөвч, ширмэн таг, дулаалгатай хуванцар хоолой /ф тодорхойгүй/ м- 38833₮, хагас цилиндр хэлбэрийн хөөсөнцөр 66400₮ гэх мэтийн үнийг хяна. судалж бодит үнээр тусгах, жигдэлж зас.	жигдэлж заслаа
18	23. Гинтигны гурил, гантигны үйрмэг, гялтагнуур УБ-аас зөөх, тээвэр 611,8 мянган₮, модоо хаалга 4,2м2-1648 кг буюу 1м2-392,4 кг тээвэр нь 518,1 мянган₮, шохой зуурмаг УБ-аас зөөх, 5тн гантигны үйрмэг 2,2 сая ₮-өөр тээвэрлэх гэх мэтийг хянаж зас, хас. Ер нь ийм хачин нэр төрөл, жин агуулсан материал ямар программаар гараад байна вэ? Эстиматор про программ шинэчлэгдээд 4 хувилар гарсан. Үүгээр хий.	хэрэгцээгүй хачин нэр төрлийн материалуудыг нь бүгдийн хасаж засварлалаа.
19	24. Зураг, зургийн түүврээс зөрөөтэй зүйлүүд байна. Зургийн ажил, материалын түүвэртэйгээ сайн тулгаж, дахин хянаж төсвөө сайжруул. 5-р баг Хар үзүүр багт л гэхэд Гадна усан хангамжийн ажилд ф2000-ын 1 худаг угсрах ажил гэж байхад материалд КС-7-1-2,7-1-1 тус бүр 2ш байх юм. Төсөвчин энэ бүх зүйлийг анхаарч судалж хийх. Асуух лавлах зүйл байвал хариулт өгч болно.	Зургийн түүвэр дээр тусгаснаар авсан болно.
20	25. Дээр дурьдсан бүхнийг 7 төсөвтөө нэг бүрчлэн засч, төсвөө сайжруулж хий. Зөвлөсний дагуу төсвийн бүтэц, нэр бүрдлийг гүйцээх.	гүйцэтгэсэн

Д/ д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Биелэлт
21	26. Бүх төсвөө нягталж засварлаад, төсөв тус бүрийн батлагдах эцсийн дүнг төсвийн нэрээр тус бүрээр энд бич.	50 Хүүхдийн сургууль, дотуур байр (5 улиас баг) - 193 449 968 Уг төсөв дээр тунгаагуур буюу цэвэрлэх байгууламжийн ажил болон материалыг орхигдуулсан байсан тул нэмж засаж бодон тооцов. 50 Хүүхдийн сургууль, дотуур байр (Хар үзүүр баг) - 118 492 323 Уг төсөв дээр гадна тохижилтын хашаа хайсны ажлыг нэмж тусган засаж тооцов. 75 Хүүхдийн цэцэрлэг - 39 506 421 80 Хүүхдийн дотуур байр - 60 439 441 100 Хүүхдийн 1-р дотуур байр - 69 940 730 100 Хүүхдийн 3-р дотуур байр - 58 250 597 320 Хүүхдийн сургууль - 54 644 632 400 Хүүхдийн сургууль - 99 018 173
<p>Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № 9-1 Ү.Банди/</p> <p>2023 оны 11 сарын 09 өдөр</p> <p>Биелэлтийн тайлбар бичсэн Сумъяа/</p> <p>2023 оны 11 сарын 09 өдөр</p> <div style="text-align: right;">   </div>		